

Салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам), Баярмагнай Манлай

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
	1	2	3	4	5	6	7	
<p>1.1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу бүс нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэл, нийгмийн хөгжлийн бодлого, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд холбогдох мэдээллээр яамны бусад нэгжийг хангах;</p>								
1	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулна.	Боловсруулах бодлогын баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг батлуулсан.	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. /Нийт 6 бодлогын баримт бичиг/	6	Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслүүдийг ажлын хүрээнд Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Байгаль орчны зорилтот хөтөлбөр, Засаглалын зорилтот хөтөлбөр, Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийн төслүүдийг боловсруулж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

2	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	Боловсруулах төлөвлөлтийн баримт бичгийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын хавсралтаар "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г батлуулсан.	"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. /1 төлөвлөлтийн баримт бичиг/	Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г хэлэлцүүлэн батлууллаа. Уг төлөвлөгөө нь "Хүн төвтэй" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох"-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн дөрвөн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, нийтдээ 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Эдийн засгийн эрх чөлөөний реформын хүрээнд бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%
---	--	--	---	--	---	--	------

				<p>шинэчилж, татварын орчны шинэчлэлийг хийж, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөрөнгө оруулалтыг хязгаарласан, хаасан зохицуулалтыг багасгах, ялгамжтай байдлыг арилгана. Төсвийн зардлын реформын хүрээнд төсвийн урсгал зардлыг ДНБ-ий 24 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, процессын дахин инженерчлэлийг хийж, төрийн үйлчилгээг хялбар, хүн төвтэй, про-актив хандлагаар эрчимжүүлнэ. Төрийн албаны реформын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ. Үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформын хүрээнд төрийн өмчит компаниудын реформыг эрчимжүүлж, бүтээмжийг сайжруулж, зардлыг бууруулж, тэдгээрийн хөрөнгийн удирдлагыг сайжруулна. Баялгийн</p>		
--	--	--	--	--	--	--

					санг арвижуулж, геологи, хайгуул, болон ашиглалтын түвшнийг нэмэгдүүлэх, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц арга хэмжээг хэрэгжүүлж, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" нь үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчимд суурилсан, урт, дунд хугацааны хөгжлийн		
1.2. Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, салбар хоорондын бодлогыг уялдуулж, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;							
3	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгнө.	Арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх, хувиар	-	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж, улс, бүс, орон нутаг, салбар хооронд нэгтгэн зохион байгуулж, уялдааг хангаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г батлуулсан бөгөөд Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "ХҮН ТӨВТЭЙ" хөгжлийн үзэл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					санаанд нийцсэн “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ”-ыг зорих бөгөөд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.		
4	Олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар судалж, боловсруулна.	Судалгаа хийж, хөгжлийн загвар боловсруулсан байх, хувиар	-	Өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулж байна. /100 хувь/	Монгол улсын дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг батлуулан, Үнэлгээний хороог байгуулсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуулийн дагуу худалдан авах зөвлөх үйлчилгээг зарлаад байна. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.1.5-д “Улсын Их Хурлаас гаргаж байгаа бодлого нь нотолгоонд суурилсан байх тогтолцоог бүрдүүлж, батлан гаргаж байгаа нийт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>бодлогын 70 хувиас доошгүйг судалгаанд суурилж боловсруулна.” гэж заасан. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад бүс, орон нутгийн онцлогт нийцүүлсэн, салбар болон салбар хоорондын уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтүүдийн талаар нарийвчилсан тооцоо, судалгаа хийх зайлшгүй шаардлага бий болсон. Дээрх цогц судалгааны ажлын хүрээнд: -Монгол улсын дунд хугацааны бодлого, төлөвлөлт, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг тоон утгаар чанаржуулах цогц судалгаа хийхийн тулд олон төрлийн өгөгдлүүд, загвар ашиглах; -Уялдаа холбоотой системүүдийн хөгжлийг загварчлах, орон нутаг болон салбар хоорондын харилцан үйлчлэлийг харах зорилгоор Системийн динамик (System Dynamics) загвар ашиглах; -Орон нутаг, салбар хоорондын өөрчлөлтүүдийн нөлөөг</p>	
--	--	--	--	--	--	--

					тооцоолох Динамик симуляц ашиглах зэрэг хөгжлийн загваруудыг хөгжүүлнэ.		
5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулна.	Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байх, хувиар	-	Эхний хагас жил: Хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулж байна. /100 хувь/	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг тасралтгүй хэрэгжүүлж байна. Тухайлбал, Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгаж, төрийн албан хаагчдын тоог (багш, эмч нараас бусад) 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийсний үндсэн дээр зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар төрийн бүтээмжийг дээшлүүлж, төрийн худалдан авалтад хиймэл оюуныг ашиглан ил тод байдлыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх талаар тооцоо, судалгаа хийв. Мөн Монгол Улсын хэмжээнд цогц үйлчилгээний төвүүдийг байгуулах, ажлын байрыг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					нэмэгдүүлэх талаар судалгаа хийлээ. Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр дараах сургалтыг зохион байгууллаа. Үүнд: -"Олон хэвт эдийн засаг, суртахууны эдийн засаг" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр яамны албан хаагчдад зохион байгуулав.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн эрх асуудлын хүрээнд хурал, зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлэгт оролцох	Өөрийн эрх асуудлын хүрээнд хурал, зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлэгт оролцсон байх	-	Өөрийн эрх асуудлын хүрээнд хурал, зөвлөгөөн, сургалт, хэлэлцүүлэгт оролцсон байна.	Өөрийн эрх асуудлын хүрээнд ЦХИХХЯ-ны зохион байгуулсан "Хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээ ба стратеги төлөвлөлт" хэлэлцүүлэг, НҮБ-ийн "Хиймэл оюуны чадавх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р	100%

			/100 хувь/	хөгжүүлэх” сургалт,	сар		
2	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд судалгааны арга зүй, мэдээллийн технологийн ур чадварт суралцах	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд судалгааны арга зүй, мэдээллийн технологийн ур чадварт суралцсан байх	-	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд судалгааны арга зүй, мэдээллийн технологийн ур чадварт суралцсан байна. /100 хувь/	Power BI ашиглан дашбоард ба өгөгдлийн анализ хийх сургаалтанд хамрагдаж Өгөгдлийн загварчлал – харилцан холбоос (relationships), DAX функцүүдээр шинэ хувьсагч, хэмжүүр бий болгох ур чадварт суралцсан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ХЯНАСАН :

Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх

.....


 ТУ32864 6805236 9022010236
 ТАЙЛАН ТАРГАСАН:

Огноо: 2025.06.25

Салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам), Баярмагнай Манлай

.....


Огноо: 2025.06.25